

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД НИСГЭГЧГҮЙ ОНГОЦ /ТӨХӨӨРӨМЖ/ АШИГЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES REGARDING THE USE OF UNMANNED AERIAL VEHICLES IN POLICE OPERATIONS



М.БАТБАЯР

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын Дүн шинжилгээ, судалгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа, магистрант

BATBAYAR M (M.L.Student & Police Lt.Colonel)

Senior Specialist of the Research and Analysis Division of the Information Integration and Analysis Department, National Police Agency of Mongolia

Товч агуулга: Энэхүү өгүүллээрээ цагдаагийн байгууллагын хууль сахиулах үйл ажиллагаа, тэр дундаа нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд нисэгчгүй онгоц ашиглах хэрэгцээ, шаардлага, ач холбогдол, ашиглаж буй өнөөгийн байдал, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт болон гадаадын зарим улс оронд нисэгчгүй онгоц ашиглаж буй туршлага, ашиглах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх арга зүйн зарим асуудлын талаар товч авч үзлээ.

Abstract: This article explores the necessity and significance of using unmanned aerial vehicles (UAV) in law enforcement operations for ensuring public order and safety. It also discusses about the legal environment for using such equipment and examines the practices of foreign countries, offering possibilities of improving the use of UAVs.

Түлхүүр үгс: Иргэний агаарын нисэгчгүй нисэх төхөөрөмж, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, эргүүл, харуул, хамгаалалт, хяналтын төв, дүрс бичлэг

Keywords: civil unmanned aerial vehicles, public order, public safety, crime, preventative action, patrol, guard, security, control center, video

Үндсэн хэсэг

Сүүлийн жилүүдэд олон улсад бидний хэлж сурснаар дрон буюу нисэгчгүй онгоцны (НИСЭГЧГҮЙ ОНГОЦ) хэрэглээ ихээр нэмэгдсээр байна. Дэлхийн 90 гаруй улсад нисэгчгүй онгоцны төрөл бүрийн зорилгоор ашиглаж байгаа бөгөөд эдгээрээс 30 гаруй улсад цэргийн зориулалтаар ашиглаж байна.

Дрон буюу нисэгчгүй онгоц гэдэг нь агаарын орон зайд нисэгчгүйгээр буюу алсын зайны удирдлагатай, бага оврын хэмжээтэй нисдэг төхөөрөмжийг хэлнэ.

Өнөөдөр энэ төхөөрөмжийг агаарын нисэгчгүй онгоц, тэнгэрийн нүд, нисэгчгүй агаарын тээврийн хэрэгсэл, агаарын камер гэх зэрэг олон янзаар нэрлэж байна. Нисэгчгүй онгоц нь янз бүрийн хэлбэр, дизайн, хурдтай, техникийн үзүүлэлт нь өөр өөр байхаас гадна гүйцэтгэж буй үүрэг нь бас харилцан адилгүй байна¹.

Өөрөөр хэлбэл, нисэгчгүй онгоцыг зөвхөн байлдааны талбарт цэргийн зориулалтаар ашиглаж байсан бол өнөө үед нийгмийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан камер суурилуулж хэмжээг нь багасган хууль сахиулах ажиллагаа, байгалийн гамшигт үзэгдэл болон хүний хор уршгаар бий болсон осол яваар, тагнуулын үйл ажиллагаа, телевизийн нэвтрүүлэг, шуудан хүргэлт, спортын уралдаан тэмцээн, хөдөө аж ахуйн салбарт гэхчлэн олон янзаар ашиглах болсон байна.

Жишээ нь: жижиг хэмжээний нисэгчгүй онгоцыг цагдаагийн байгууллага тодорхой нутаг дэвсгэрт нийтээр дагаж мөрдөж дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих, хэргийн газрын үзлэгийг агаар дээрээс баримтжуулах, гэмт этгээдийг мөрдөн хөөх, нийтийг хамарсан арга хэмжээний нөхцөл байдлыг хяналтдаа авч, хүч хэрэгслийг хуваарилахад ашиглах, онцгой байдлын байгууллага агаараас гал унтраах бодис цацаж түймэр унтраах, хилийн тагнуулын алба хилийн зурвасыг ажиглах, хяналт тогтоох зэрэг хэлбэрээр ашигладаг.

¹ Drones in Canada (2013, March), in Research Group of the Office of the Privacy Commission of Canada P2 retrieved from file:///C:/Users/nyambat.d/Desktop/PDF/drones%20in%20Canada.pdf



Хууль сахиулахуй

Энэ нь технологи хурдацтай хөгжихийн сацуу энгийн хялбар хийцээр дроныг зэвсэглэх боломж нэмэгдсэн бөгөөд нисэгчгүй онгоцнуудыг олон үзүүлэлт, багтаамжаар нь ангилэхдаа дараах 2 үндсэн шалгуурыг авч үзсэн. Үүнд:

1. Ямар үүрэг гүйцэтгэх зорилгоор бүтээсэн
2. Бүтээсэн технологийн бааз суурь болон дэд бүтцийн байдал.
1. Дээрх 2 үзүүлэлт үндэслэн бүх нисэгчгүй онгоцуудыг дараах 4 ангилал болгон авч үздэг байна. Үүнд
 1. Жижиг дрон
 2. Дунд оврын цэргийн болон арилжааны зориулалттай дрон
 3. Том оврын цэргийн тусгай зориулалттай дрон
 4. Үл үзэгдэгч байлдааны зориулалттай дрон

Зураг 1



Зураг 2



Зураг 1-д дүрсэлснээр, нисгэгчгүй онгоцны доод хэсэгт камер байх бөгөөд алсын зайнаас зураг авах, дүрс бичлэг хийж болох хүчин чадлаасаа хамаарч 1-5 км тойргийг хянаана.

Зураг 2 нь нисгэгчгүй онгоц болон түүний удирдлагыг харуулж байна. Ямар ч төрлийн гар утас, таблет ашиглаж болох бөгөөд түүнийг камертай сүлжээгээр холбож дэлгэц болгон ашиглана. Хөөрөх, буух, баруун, зүүн эргэхийг алсын удирдлагаар жолоодох бол ухаалаг гар утас болон таблет агаарт буй камерын дэлгэцийн үүрэг гүйцэтгэнэ.

Нисэгчгүй онгоцны ангиллууд (ITU-R Report M.2171)

Нисэгчгүй онгоцыг жижиг, дунд, том гэсэн ангилдаг байна. Нисэгчгүй онгоцыг дараах шалгуур үзүүлэлтийг харгалзан ангилна. Үүнд:

- Жин (Kg)

- Хамгийн их өндөр (м)
- Хурд (Км/ц)
- Агаарт байх (Цаг)
- Холбооны шугамын хамгийн их зай (Км)

Олон улсын агаарын орон зайн ангиллын хувьд авч үзвэл жижиг нисэгчгүй онгоц нь G ангиллын агаарын орон зайд, дунд нисэгчгүй онгоц нь A ангиллаас бусад бүх агаарын орон зайд, харин A ангиллын том нисэгчгүй онгоц нь бүх ангиллын агаарын орон зайд ажиллана гэж стандартад тодорхойлсон байна.²

Гадаадын зарим улс орны цагдаагийн байгууллагаас нисгэгчгүй онгоцыг хууль сахиулах ажиллагаанд ашиглаж буй туршлагаас авч үзье.

Нисгэгчгүй онгоцыг дэлхийн 50 орчим улсад үйлдвэрлэж байна. Жишээ нь: Хятад, АНУ, Канад, Израйл, Ирак зэрэг улсууд маш идэвхтэй энэ талаар судалж, хөгжүүлж, үйлдвэрлэл, технологийг улам бүр шинэчилж байдаг.³

Зарим улс орны цагдаагийн байгууллага нисгэгчгүй онгоцыг үйл ажиллагаандаа ашиглаад 10 орчим жил болж байна. Тухайлбал:

GERMAN УЛС: Нийтийн эзэмшлийн гудамж талбай, хана, төмөр замын буудал зэрэг газарт шүршдэг өнгийн будгаар зураг зурахыг гэмт хэрэгт тооцдог бөгөөд жил бүр 10 сая орчим ам доллар зарцуулж буцааж будаж цэвэрлэдэг гэсэн тооцоо бий⁴.

Ингээд 2013 онд нэг бүр нь 78.600 ам долларын үнэтэй, 145 метрийн тойргийг хянах хүчин чадалтай, дулаан мэдрэгч камер суурилуулсан нисгэгчгүй онгоцыг дээрх гэмт хэрэг ихээр үйлдэг газруудад хөөргөж туршиж эхэлсэн. Гэвч Германы Хууль бусаар мөрдөн мөшгөх тухай хуульд зааснаар нисгэгчгүй онгоц хувь хүний нууцад зөвшөөрөлгүй халдаж байна гэсэн үндэслэлээр туршилтыг түр зогсоосон.

ЭНЭТХЭГ УЛС: Тус улсын маш олон цагдаагийн газар, хэлтсүүд нисгэгчгүй онгоц ашиглаж байна. Энэ нь аливаа хууль тогтоомж зөрчсөн үйлдэл биш бөгөөд прокурорын зөвшөөрлөөр хийдэг байна. Тухайлбал, 2013 онд зохион байгуулагдсан олон улсын 5 км-ын холын зайн гүйлтийн тэмцээний үеэр нисгэгчгүй онгоц ашигласан

² Ч.Тэрбиш. Нисгэгчгүй онгоцны системийн аюулгүй ажиллагаанд зориулсан радио давтамжийн спектрийн шаардлага, техникийн үзүүлэлтүүд, зохицуулалтын тухай (судалгаа). УБ., 2016. 4 дэх тал

³ Unmanned Flight (Horgan, 2013) in National Geographic, retrieved from <http://ngm.nationalgeographic.com/2013/03/unmanned-flight/horgan-text>

⁴ German railways to test anti-graffiti drones (Evans, 2013) in BBC news, retrieved from <http://www.bbc.com/news/world-europe-22678580>

туршлагыг дурдаж болно.

Тэмцээний үеэр ойролцоогоор 20.0 орчим автомашин, 5000 орчим унадаг дугуйг зогсоолд байршуулах, тэмцээнд оролцогч 180.000 хүний аюулгүй байдал, тэмцээн хэвийн явагдах нөхцөлийг хангахаар агаарт 200 метрийн өндрөөс олон арван төхөөрөмж нисгэн хянасан⁵.

Ням гариг бүр болдог шашны томоохон үйл явдлын үеэр хэв журам сахиулахаар 500 гаруй томоохон хот, дүүрэгт нисгэгчгүй онгоцыг ашиглаж байна.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС:

Нисгэгчгүй онгоцыг цэргийн зориулалтаар ашиглаад удаж байгаа боловч цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд 2011 оноос эхэлж хэрэглэж эхэлсэн.

Учир нь нисгэгчгүй онгоцноос авч байгаа мэдээлэл нь хувь хүний нууцтай холбоотой хэмээн Үндсэн хуулийн хүний эрхтэй холбоотой 3-5 дугаар заалтуудтай зөрчилддөг. Гэвч Хойд Дакота муж анх удаа нисгэгчгүй онгоцыг цагдаагийн байгууллагадаа ашиглахыг зөвшөөрсөн.

1989 оны *Флорида Ралийгийн эсрэг, 488 U.S. 445* гэх хэрэгт Дээд шүүхээс цагдаагийн байгууллага нийтийн агаарын орон зайд ажиглалт хийх нь иргэний хувийн нууцад халдаагүй гэсэн шийдвэрийг гаргасныг иш болгон (аль ч шатны шүүхийн шийдвэр нь хуультай ижил үйлчилдэг) зарим муж өөрсдийн хууль тогтоомжоо өөрчилж байгаа.

Жишээлбэл, 2014 онд Калифорн мужийн Сенатаас хууль сахиулах болон бусад төрийн байгууллага нисгэгчгүй онгоцыг үйл ажиллагаандаа ашиглаж болох ба нэн яаралтайгаас бусад тохиолдолд заавал шүүхээс зөвшөөрөл авч байхаар хууль баталсан.

ИХ БРИТАНИ: Анх 2010 онд Английн Мерсесайд хотын цагдаагийн газрынхан нисгэгчгүй онгоц ашиглан хулгайчийг үйлдэл дээр нь баривчилсан. Гэвч үүнээс 7 хоногийн дараа Засгийн газраас нисгэгчгүй онгоцыг ашиглахын тулд Иргэний нисэхийн ерөнхий газраас зөвшөөрөл авч байх, зөвшөөрлийн тодорхой хугацааны сургалтад хамрагдсан албан хаагчдад өгч байхаар шийдвэрлэсэн.

Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага алба хаагчаа сургах, нисгэгчийн онгоц худалдан авах зардал хэт өндөр тул үүнийг ашиглах үйл ажиллагаа зогсонги байдалд орсон.

Харин 2014 онд нисгэгчгүй онгоцноос Английн Цагдаагийн дарга нарын холбоо нисгэгчгүй онгоцноос санхүүжүүлж эхэлсэн мөн энэ үед дэвшилтэт технологи ашиглах

журам батлагдсантай холбоотойгоор цагдаагийн газруудын нисгэгчгүй онгоц ашиглах эрмэлзэл сэргэж ирсэн. Жишээ нь: Суссек хотын цагдаагийнхан тэдний санхүүжилтээр 35.000 еврогийн үнэтэй нисгэгчгүй онгоц худалдаж авсан бөгөөд 4 алба хаагчийг 10.000 евро төлж сургалтад хамруулсан байна⁶.

БУСАД: БНХАУ-ын аймаг, хотуудын цагдаагийн газрууд харилцан адилгүй олон төрөл, загварын нисгэгчгүй онгоцыг ашиглаж байна. Мөн ОХУ-ын замын цагдаагийн албанд ашигладаг. Жишээ нь: Үзэгдэх орчин хязгаарлагдмал үед төхөөрөмжийг дээш хөөргөж замын хөдөлгөөний дүрмийг зөрчиж буй эсэхийг хянана.

Монгол Улсад нисгэгчгүй онгоцыг төрийн байгууллагаас гадна хувийн хэвшлийнхэн өргөнөөр ашиглаж байна. Тухайлбал, зарим телевизийн аялал жуулчлалын нэвтрүүлэг, морь, дугуйн уралдаан зэргийг сурвалжлах үед, барилгын компани талбайн хяналт тавих зэрэгт ашиглаж байна. Жишээ нь: АСЕМ-ийн зочдод зориулан Богд ууланд барьсан 2 км орчим үргэлжилсэн барилгын явцад талбайн хяналтыг нисгэгчгүй онгоц ашиглан гүйцэтгэж байсан.

Төрийн байгууллагуудын хувьд Шүүхийн шинжилгээний хүрээлэн 2016 оны 2 сард нисгэгчгүй онгоц нэг ширхгийг худалдаж авч хүнд, онц хүнд гэмт хэргийн газрын үзлэгт ашиглаж байна. Жишээ нь: 2016 оны 4 дүгээр сард Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт хэн болох нь тодорхойгүй шатсан цогцос олдсон хэрэгт газар нутгийн төлөв байдлыг тогтоох, гэрэл зураг авах, дүрс бичлэг хийх, нотлох баримт хайх, баримтжуулах зорилгоор ашигласан нь хэргийн амжилттай мөрдөхөд үр дүнгээ өгсөн байна.

Мөн Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хариуцсан нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон нисдэг камер ашиглан хэв журмын эргүүл шалгалт хийлгүүлэхээр шийдвэрлэн DJI Phantom 4 маркийн 12 мегапикселиер зураг авах болон 4к чанартай бичлэг хийдэг нисгэгчгүй онгоцыг худалдан авч 2016 оны 3 дугаар сараас эхэлж дүүргийн цагдаагийн II-р хэлтэст ашиглаж байна⁷.

⁶ Radio-controlled aircraft trialed by Gatwick police (Sussex Police Department, 2014) in BBC News, retrieved from <http://www.bbc.com/news/uk-england-sussex-26544168>

⁷ Сонгинохайрхан дүүрэгт агаарын эргүүл ажиллаж эхэллээ (Wikimon, 2016), in <http://www.wikimon.mn/content/68111.shtml#sthash.zTNI1HHX.dpuf>

⁵ Gujarat Police to use UAV for security during 'Run for Unity' marathon (Vadodara, 2013)



Хууль сахиулахуй



Хууль сахиулахуйн инноваци

Зураг 4



Зураг 5



Тус цагдаагийн хэлтсээс мэдээлж буйгаар одоогийн байдлаар гэмт хэрэг үйлдэж болзошгүй 1025 субъектийн, гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй 531 объектын мэдээллийг газрын зураг дээр байршуулан баяжилтыг хийж орчин үеийн шаардлага хангасан цахим сан байгуулах зорилт тавин ажиллаж байна.

Нисгэгчгүй онгоцыг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд ашиглах хууль, эрх зүйн үндэслэл:

Өнөөдөр цагдаагийн байгууллага нисгэгчгүй онгоцыг дараах хууль, эрх зүйн үндэслэлийг удирдлага болгон үйл ажиллагаандаа ашиглана. Үүнд:

- Цагдаагийн албаны тухай хуулийн 11.1.2. "гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих"⁸ гэж заасан нь ашиглах гол эрх зүйн үндэслэл болж байна.

- Инновацийн тухай хуулийн 10-р зүйлийн 10.1 дэх хэсэгт "...агентлаг дангаараа

болон хамтран инновацийн хөтөлбөр, төсөл боловсруулан хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх эрхтэй" гэж заасан нь Цагдаагийн байгууллага нь "нисгэгчгүй онгоц инноваци хөтөлбөр" боловсруулан түүнийхээ дагуу шаардлагатай төхөөрөмжийг худалдан авч санхүүжүүлэх эрхтэй байна.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт "тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял оногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ"⁹.

Мөн хуулийн 19-р зүйлийн 19.3.5. хэсэгт "цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх" гэсэн заасан зэргээс үзэхэд аймаг, нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс нисгэгчгүй онгоц төслийг санхүүжүүлэх боломжтой байна.

- Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9-р зүйлийн 9.4 хэсэгт "Гүйцэтгэх ажил явуулахдаа холбоо, мэдээллийн систем, гэрэл зураг, нисгэгчгүй онгоц, дүрс, дууны болон бусад бичлэг хийх, хүний амь бие, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюулгүй бусад техник хэрэгсэл ашиглана"¹⁰ гэсэн нь нисгэгчгүй онгоц ашиглах эрх зүйн үндэслэл болж байна.

Нисгэгчгүй онгоцыг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл:

Дэлхийн электроник хэрэглэгчдийн холбоо байгууллагаас жил бүр үзэсгэлэн худалдаа зохиогддог бөгөөд 2015 онд Air-Dog, Squadrone, Trace, DJI, iRobot, Trace, Torquing Group DBA ZANO, Ecovacs, EHang, Autel, Pelican Products зэрэг олон арван компаниуд нисгэгчгүй онгоцоо танилцуулсан¹¹.

Дулаан мэдрэгч камертай, шөнийн линзтэй, асар хурдтай, өндөрт хөөрөх чадвартай, агаарт удаан хугацаагаар тогтдог, 3D бичлэг хийдэг, удирдлагын дэлгэц нь Google glass шиг, нулимс асгаруулагч цацдаг, резин сумаар бууддаг зэрэг нэмэлт төхөөрөмжтэй, техникийн маш

⁹ Төрийн мэдээлэл. УБ. 1992. №4-5

¹⁰ Төрийн мэдээлэл. УБ. 1999. №3

¹¹ Unmanned Systems Take Flight at the 2015 International CES (CES, 2015) in CES Press Release, retrieved from <http://www.ces.tech/News/Press-Release/CES-Press-Release.aspx?NodeID=a8cf1815-ad54-4bfd-9e70-62d7e4a1868a>

өндөр үзүүлэлттэй нисгэгчгүй онгоцны үнэ нь 50.000 ам доллар орчим.

Харин дундаж үнэ бүхий, техникийн үзүүлэлт сайтай Phantom загварын нисгэгчгүй онгоц хамгийн их зарагдсан мэдээ байна¹².

Жишээлбэл, зарим орны цагдаагийн байгууллага болон СХД-н II-р хэлтэс Phantom4, Шүүхийн шинжилгээний хүрээлэн нь Phantom 2 загварыг ашигладаг. Техникийн үзүүлэлт сайтайгаас гадна манай улсын эрс ширүүн уур амьсгал, ширүүн салхитай, өвлийн хүйтэнд тэсвэртэй зэрэг шалтгаанаар хувийн хэвшлийнхэн мөн энэ загварыг ашиглаж байна. Жишээ нь: MCS компани.

Phantom 4-ийг Amazon.com дээр худалдаалж байгааг танилцуулбал:

Төхөөрөмжийн хэмжээ	37.5 x 21.75 x 32 см
Төхөөрөмжийн жин	4 кг
Шуудангаар явуулах жин	4.1 кг
Үнэ (1ш зай дагалдаж ирнэ)	\$1,384 /илүү зай авбал \$200нэмэгдэнэ/
Өнгө	цагаан
Камер	12 мега пиксельтэй 1 секундэд 30 гэрэл зураг авна 1080р үзүүлэлтээр бичлэг хийнэ.
Хөөрөх үзүүлэлт	Бүтэн зайгаар 28 минут агаарт тогтох нисгэгчгүй онгоц 72км/ц-ийн хурдтай ниснэ 5км-ийн тойргийг хянаана 20м/с-ийн хурдаар хөөрөх чадвартай Газраас 500м –т дээш хөөрнө 15м/с доош хурдтай салхитай үед хөөрнө

Нисгэгчгүй онгоцыг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд ашиглахын ач холбогдол

Нисгэгчгүй онгоцыг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглах нь дараах хэдэн ач холбогдлоор тодорхойлогдож байна. Үүнд:

- Агаарын эргүүлийн үүрэг гүйцэтгэнэ. Мексиктэй хил залгаа АНУ-ын нэгэн хотын цагдаагийн дарга хэлэхдээ “нисгэгчгүй онгоц нь 20 болон түүнээс дээш тооны эргүүлийн цагдаатай тэнцэхээс гадна гэмт этгээдэд харагдан өөрийг нь ажиглаж байна гэж сэтгэгдэл төрүүлж чаддаг тул урьдчилан сэргийлэх чухал үүрэгтэй төхөөрөмж юм”¹³ гэснээс үзэхэд уг төхөөрөмж морьт, явган, машинт эргүүлийн үүргийг дангаараа хийж

чадах давуу талтай.

Жишээлбэл, Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх зэрэг гэр хороолол ихтэй газруудад эргүүлийн цагдаа нэг газраас бүхий л гудамжийг нэгэн зэрэг хянах боломжтой. Мөн хэсгийн төлөөлөгч нарт хэрэглүүлснээр хулгайн анчин, модны хулгайчтай тэмцэх ажилд ахиц гарна.

- Хэргийн газрын үзлэгт ашиглана. Мөрдөн байцаагч, эрүүгийн төлөөлөгч нар хэргийн газрын үзлэгийг агаараас авч газар нутгийн онцлог, төлөв байдал, гарц, зам хаана байгааг, хаанаас ямар унаатай ирж болох юм, хаагуур тойрч явсан байж болзошгүй гэхчлэн гэмт хэрэг илрүүлэхэд тус болох чухал мэдээллийг авч чадна.

Нисгэгчгүй онгоц нь GPS-тэй тул эд мөрийн баримтыг хаанаас ямар өргөрөг, уртрагтай газраас авсныг тэмдэглэн нотлох баримтын хэмжээнд үнэлүүлж чадна. Мөн тухайн газар, нутгийн бичил газрын зурагтай болно.

- Ажиглалт, дагалдан тагнах ажиллагаанд хэрэглэнэ. Нисгэгч онгоц нь мөрдөгчийг гэмт этгээдэд харагдахгүйгээр хаана яваа, хэнтэй уулзаж буйг харах, баримтжуулах, гэрэл зураг авах, бичлэг хийх боломж олгоно.

Жишээлбэл, 2013 оны 2 дугаар сард АНУ-д Вьетнамын дайнд оролцож байсан бэлтгэл цэргийн алба хаагч Жимми Ли Дукес гэгч сургуулийн автобусыг зогсоон жолоочийг нь хөнөөн 5 настай хүүг барьцаалан авч зугтаасан хэрэг гарсан.

Барьцаалуулагчийн амь насанд эрсдэл учруулахгүйн тулд нисгэгчгүй онгоц ашиглан 6 өдрийн туршид ажигласны эцэст гэмт этгээдийг буудаж хороосон.

- Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэхэд үр дүнгээ өгнө.

2015 оны 2 дугаар сард Нидерланд улсын нэгэн хотын байшингийн дээврийн дунд хэсэгт цас хайлсан байх боловч бусад хэсэгт цастай байгааг нисгэгчгүй онгоц ашиглан мэдсэн юм.

Энэ нь хар тамхи тариалж буй шинж тэмдэг хэмээн сэжиглэн цагдаагийнхан байшинд ороход гэмт этгээд олон гэрлээр дулаахан орчин үүсгэн гэртээ 88 ширхэг каннибас ургуулж байсныг илрүүлсэн байна¹⁴. Зах зээлийн ханш нь ойролцоогоор 50.000 евро бол нисгэгчгүй онгоц.

¹² Dronefly (2016) in <http://www.dronefly.com/collections/all-drones>

¹³ To the Rescue! Why Drones in Police Work Are the Future of Crime Fighting (Alderton, 2015) in <https://lineshapespace.com/drones-in-police-work-future-crime-fighting/>

¹⁴ Melting snow being used by police to find cannabis farms in the Netherlands (Dearden 2015), in *Independent News*, retrieved from <http://www.independent.co.uk/news/world/europe/melting-snow-being-used-by-police-to-find-cannabis-farms-in-the-netherlands-10036057.html>



Хууль сахиулахуй

Зураг 5



Зураг 6

• Бусад гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглана. Тухайлбал, террорист халдлага голчлон үйлдэгдсэн улсын цагдаагийн байгууллагын тэсрэх бөмбөгний мэргэжилтэн нисгэгчгүй онгоцоор тэсрэх бөмбөг байж болзошгүй газрыг ажиглаж урьдчилан мэдсэнээр олон хүний амь нас аврагдах боломжтой болно.

• Нисгэгчгүй онгоцонд “Нүүр адилтгах програм”-ыг суулгаснаар алга болсон хүүхэд, эрэн сурвалжилж буй сэжигтэн этгээдийн царайг санд буй хүмүүстэй адилтгах, хулгайлагдсан тээврийн хэрэгслийн дугаарыг шүүж үзэх зэргээр бас ашигладаг. Жишээ нь: Охоя мужийн Дайтон хотод цагдаагийн газрынхан бүх гудамж талбайд нүүр адилтгах програмтай нисгэгчгүй онгоцыг сард 200 цаг орчим хөөргөдөг байна¹⁵.

¹⁵ To the Rescue! Why Drones in Police Work Are the Future of Crime Fighting (Alderton, 2015) in <https://lineshapespace.com/drones-in-police-work-future-crime-fighting/>

Цагдаагийн байгууллагад нисгэгчгүй онгоц худалдан авах зардлын тооцоо, тоо ширхэг

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллагад нисгэгчгүй онгоцыг түлхүү авч ашиглуулах нь зүйтэй юм. Дээрх үнийг amazon.com-оос гаргаж харсан бөгөөд нэг удаа хөөрөхөд 25-28 агаарт тогтох чадвартай тул илүү зай худалдаж авна. Энэ нь нэг бүрийн үнэ дээр 400.000 төгрөг нэмэгдэнэ.

№	Хаана	Хэдэн ширхэг	Үнэ (нэг бүрийн үнэ 3 сая төгрөг)
1	21 аймаг	21	63 сая төгрөг
2	17 дүүргийн цагдаагийн хэлтсүүд	17	51 сая төгрөг
3	МБГ	10	30 сая төгрөг
4	ЭЦГ	10	30 сая төгрөг
5	ЗЦГ	10	30 сая төгрөг
6	УБХЦГ	10	30 сая төгрөг
	42 байгууллага нэгж	78	234 сая төгрөг

Манай улсад Компьютер ланд дэлгүүрт Phantom 1-3 загварын нисгэгчгүй онгоц байх боловч хамгийн сүүлийн үеийн, үзүүлэлт сайтай Phantom 4-ийг ХУД-т байрлалтай Хобби дэлгүүрт 3.4 сая төгрөгөөр худалдаалж байна. Дээрх тоо, ширхэг нь цагдаагийн байгууллагын хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй ч гэсэн эхний удаад иргэд, төр засгийн удирдлагуудад ач холбогдлыг нь мэдрүүлэх, ойлгох, дэмжих хүртэлх ашиглагдах тоо, ширхэг гэж ойлгож болно.

Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан



сэргийлэх чухал ач холбогдолтой төхөөрөмжийг аймаг, нийслэл, дүүрэг, хорооны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан, улсын төсвөөс санхүүжүүлэх боломжтой.

Дүгнэлт

Манай цагдаагийн байгууллага гадаадын орнуудын нисгэгчгүй онгоцыг хэрэглэж буй туршлага, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх үндэслэл, ач холбогдлыг нарийвчлан судалж, шаардлагатай зардал, тоо ширхгийг нарийвчлан тодорхойлж, үйл ажиллагаандаа ашиглаж чадсанаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд дэвшил гарч, гэмт хэрэг, зөрчил буурах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Нисгэгчгүй онгоц нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ихээхэн давуу талыг бий болгох боловч нөгөө талдаа иргэн, хуулийн этгээдийн нууцад прокурор, шүүхийн зөвшөөрөлгүйгээр халдаж буй гэсэн шүүмжлэлийг дагуулах эрсдэл гарч магадгүй тул ашиглах үйл ажиллагааныхаа эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Ингээд зогсохгүй цаашид нисгэгчгүй онгоцыг хувь хүн, хуулийн этгээдийн нууцтай холбоотой мэдээллийг цуглуулах, баримтжуулах, эргүүлийн зэрэг олон зорилгоор ашиглах тул хууль тогтоомжид нарийвчлан тусгах нь гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой болно.

Санал

Нисгэгчгүй онгоцыг ашиглаж гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Тухайлбал:

1. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага болгонд нисгэгчгүй онгоц худалдан авч, үйл ажиллагаандаа ашиглах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж өгөх;

2. Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын Шуурхай удирдлагын албанд нисгэгчгүй онгоцны удирдлагын нэгж хэсгийг байгуулан, мэргэшсэн алба хаагчийг бэлтгэх;

3. Нисгэгчгүй онгоц ашигласны давуу талыг шийдвэр гаргах түвшний удирдлагад танилцуулж, агаарын орон зайн зөвшөөрлийн эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх;

Ашигласан материал:

1. Цагдаагийн албаны тухай хууль.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль.
3. Гүйцэтгэх ажлын тухай хууль.
4. Инновацийн тухай хууль.
5. Төрийн мэдээлэл. УБ. 1992. №4-5
6. Төрийн мэдээлэл. УБ. 1999. №3
7. Төрийн мэдээлэл. УБ. 2017. №8

8. Ч.Тэрбиш. Нисгэгчгүй онгоцны системийн аюулгүй ажиллагаанд зориулсан радио давтамжийн спектрийн шаардлага, техникийн үзүүлэлтүүд, зохицуулалтын тухай (судалгаа). УБ., 2016. 4 дэх тал.

Цахим эх сурвалж:

1. Drones in Canada (2013, March), in *Research Group of the Office of the Privacy Commission of Canada* P 2 retrieved from
2. <file:///C:/Users/nyambat.d/Desktop/PDF/drones%20in%20Canada.pdf>
2. Unmanned Flight (Horgan, 2013) in *National Geographic*, retrieved from
3. <http://ngm.nationalgeographic.com/2013/03/unmanned-flight/horgan-text>
3. German railways to test anti-graffiti drones (Evans, 2013) in *BBC news*, retrieved from <http://www.bbc.com/news/world-europe-22678580>
4. Gujarat Police to use UAV for security during 'Run for Unity' marathon (Vadodara, 2013)
5. Radio-controlled aircraft trialed by Gatwick police (Sussex Police Department, 2014) in *BBC News*, retrieved from
6. <http://www.bbc.com/news/uk-england-sussex-26544168>
7. <http://www.wikimon.mn/content/68111.shtml#sthash.zTN11HHX.dpuf>
8. Unmanned Systems Take Flight at the 2015 International CES (CES, 2015) in CES Press Release, retrieved from <http://www.ces.tech/News/Press-Releases/CES-Press-Release.aspx?NodeID=a8cf1815-ad54-4bfd-9e70-62d7e4a1868a>
9. Dronefly (2016) in <http://www.dronefly.com/collections/all-drones>
10. To the Rescue! Why Drones in Police Work Are the Future of Crime Fighting (Alderton, 2015) in <https://lineshapespace.com/drones-in-police-work-future-crime-fighting/>
11. Melting snow being used by police to find cannabis farms in the Netherlands (Dearden 2015), in *Independent News*, retrieved from
12. <http://www.independent.co.uk/news/world/europe/melting-snow-being-used-by-police-to-find-cannabis-farms-in-the-netherlands-10036057.html>
13. To the Rescue! Why Drones in Police Work Are the Future of Crime Fighting (Alderton, 2015) in <https://lineshapespace.com/drones-in-police-work-future-crime-fighting/>
14. <http://legaldata.mn/b/151>



Хууль сахиулахуй